

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА,  
САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2021 оны \_\_ сарын \_ өдөр

Дугаар

Улаанбаатар хот

“Малын индексжүүлсэн даатгалын давхар даатгалын компанийн санг бүрдүүлэх, байршуулах, зарцуулах, түүнд хяналт тавих журам” батлах тухай

Монгол Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 3.2 дахь хэсэг, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 27.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Давхар даатгалын компанийн малын индексжүүлсэн даатгалын санг бүрдүүлэх, байршуулах, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ журмыг 2021 оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газар /Ц.Зоригтбат /-т тус тус даалгасугай.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГА

САНГИЙН САЙД

Д.БАЯРСАЙХАН

Б.ЖАВХЛАН

Санхүүгийн зохицуулах хорооны дарга,  
Сангийн сайдын 2021 оны ... сарын ... өдрийн  
..... тоот хамтарсан тушаалын хавсралт

## **МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ДАВХАР ДААТГАЛЫН КОМПАНИЙН САНГ БҮРДҮҮЛЭХ, БАЙРШУУЛАХ, ЗАРЦУУЛАХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасан давхар даатгалын компани /цаашид “давхар даатгагч” гэх/-ийн санг бүрдүүлэх, байршуулах, зарцуулах болон түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### **Хоёр. Давхар даатгагчийн санг бүрдүүлэх**

2.1. Хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1-д заасан сан буюу дунд түвшний эрсдэлээс хамгаалах санг даатгагчаас төвлөрүүлсэн давхар даатгалын хураамжийн цэвэр орлогоос актуар тооцооллоор тооцож байгуулах бөгөөд уг тооцоололд энэ журмын 2.4-т заасныг үндэслэнэ.

2.2. Хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2-т заасан сан буюу дээд түвшний эрсдэлээс хамгаалах санг Засгийн газраас төвлөрүүлсэн давхар даатгалын хураамжийн цэвэр орлогоос актуар тооцооллоор тооцож байгуулах бөгөөд уг тооцоололд энэ журмын 2.4-т заасныг үндэслэнэ.

2.3. Хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3-т заасан сан буюу алдагдлаас хамгаалах санг бүрдүүлэх, байршуулах, зарцуулахад Хорооноос баталсан “Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-ыг баримтална.

2.4. Дунд түвшний болон дээд түвшний эрсдэлээс хамгаалах сангийн актуар тооцоололд Үндэсний статистикийн хорооноос гаргасан сумын малын төрөл тус бүрийн хорогдлын статистик мэдээллийг ашиглана.

2.5. Гадаадын давхар даатгагчид шилжүүлэх давхар даатгалын хураамжийг давхар даатгагч нь даатгагчийн болон Засгийн газрын өмнө хүлээсэн үүргээ бүрэн, эсвэл хэсэгчлэн гадаадын давхар даатгагчид даатгаж төлсөн болон төлөхөөр тооцсон дүнгээр тодорхойлно.

2.6. Даатгагчийн болон Засгийн газрын давхар даатгалын хураамжийн орлогоос гадаадын давхар даатгагчид шилжүүлсэн давхар даатгалын хураамжийг хасч хураамжийн цэвэр орлогыг тодорхойлно.

2.7. Давхар даатгалын хураамжийн цэвэр орлогод давхар даатгагчийн үйл ажиллагааны зардал, ашиг багтана.

## **Гурав. Давхар даатгагчийн сангаас хөрөнгө оруулалт хийх**

3.1. Давхар даатгагч нь хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 болон 27.1.2-т заасан сангуудыг энэ журамд заасны дагуу байршуулж, хөрөнгө оруулалт хийх бөгөөд алдагдлаас хамгаалах санг байршуулах, хөрөнгө оруулалт хийхдээ энэ журмын 2.3-т заасныг баримтална.

3.2. Давхар даатгагчийн сангаас хөрөнгө оруулалт хийхдээ учирч болох дараах эрсдэлүүдийг тооцоолно:

3.2.1. Зах зээлийн эрсдэл. Зах зээлийн үнийн өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ болон ирээдүйн мөнгөн гүйлгээ хэлбэлзэх эрсдэл. Үүнд хүүгийн түвшний эрсдэл, валютын ханшийн эрсдэл болон бусад үнийн эрсдэл хамаарна.

3.2.2. Авлагын эрсдэл. Үнэт цаас гаргагч, харилцагч түнш болон мэргэжлийн оролцогч байгууллагуудын санхүүгийн байдал муудах, үүнээс болж үнэт цаас хугацаандаа төлөгдөөгүйн улмаас даатгагч санхүүгийн хохирол амсах эрсдэлтэй. Энэ төрлийн эрсдэлд үнэт цаас төлөгдөхгүй байх, үнэт цаас гаргагчийн үнэлгээ буурах зэрэг эрсдэлүүд орно.

3.2.3. Хөрөнгийн хөрвөх чадварын эрсдэл. Даатгуулагчдад их хэмжээний даатгалын нөхөн төлбөр олгох шаардлагатай тохиолдолд даатгагчийн хөрөнгийн хөрвөх чадвар хүрэлцэхгүйн улмаас бэлэн мөнгөний дутагдалд орох эрсдэлтэй. Ийм төрлийн эрсдэлд хөрвөх чадварын үнэлгээний эрсдэл, салбаруудад оруулсан хөрөнгийн хөрвөх чадварын эрсдэл, хөрөнгийн сангийн эрсдэл зэрэг эрсдэлүүд орно.

3.3. Давхар даатгагчийн гүйцэтгэх удирдлага нь зөвхөн төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн хурлаар баталсан давхар даатгагчийн сангаас хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалт хийх бөгөөд уг төлөвлөгөөнд энэ журмын 3.2-т заасан эрсдэлийг тооцоолж эрсдлийг удирдах бодлого, стратегийг тусгаж, хэрэгжүүлнэ. Мөн давхар даатгагчийн сангийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг давхар даатгагчийн санхүүгийн төлөвлөгөөнд тусгасан байна.

3.4. Давхар даатгагчийн сангаас Даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан хязгаарлалтаас гадна дараах этгээдэд хөрөнгө оруулалт хийхийг хязгаарлах бөгөөд энэхүү этгээд нь давхар даатгагчийн сангаас хөрөнгө оруулалт хийхэд эрсдэл бүхий этгээдэд тооцогдоно:

3.4.1. Даатгалын тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан холбогдох этгээд;

3.4.2. Давхар даатгагчийн болон холбогдох этгээдийн хувь нийлүүлэгч болон хувьцаа эзэмшигч;

3.4.3. Давхар даатгагчийн хувь нийлүүлэгч, ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, даатгалын салбарын захирал, тэдгээрийн өвөг эцэг, эмэг эх, эцэг, эх, эхнэр, нөхөр, ах, эгч, дүү, хүүхэд болон тэдэнд хяналтын багцаа эзэмшүүлдэг хуулийн этгээд, уг хуулийн этгээдийн хяналтын багцыг эзэмшдэг аливаа иргэн, хуулийн этгээд;

3.4.4. Холбогдох этгээдтэй хэрэг, маргаан үүссэний улмаас эрх бүхий байгууллагаар хянагдаж, шалгагдаж байгаа этгээд;

3.4.5. Даатгалын компани өөрөө холбогдох этгээд гэж үзсэн бусад этгээд.

3.5. Давхар даатгагч нь ТУЗ-ийн хурлаар баталсан төлөвлөгөөний дагуу давхар даатгагчийн сангаас хөрөнгө оруулалт хийх бөгөөд энэ журмын 3.6-д заасан шаардлагад нийцүүлнэ.

3.6. Давхар даатгагчийн санг байршуулах, хөрөнгө оруулалт хийхдээ дараах ангилал, хэмжээ хязгаарт нийцүүлнэ:

<b>Хөрөнгийн ангилал</b>	<b>Хөрөнгө оруулах дээд хувь</b>
3.6.1. Засгийн газрын өрийн хэрэгсэл	100%
3.6.2. Банкны хадгаламж /Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-д заасан шаардлагыг хангасан банканд байршуулсан/	100%
3.6.3. Банкны хадгаламжийн сертификат /Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-д заасан шаардлагыг хангасан банканд байршуулсан/	80%
3.6.4. Төв банкны үнэт цаас /Монгол банкны мөнгөний бодлогын нээлттэй захын хэрэгсэл бөгөөд хямдруулсан хэлбэрээр арилжигдаж, тогтоосон хугацааны дараа нэрлэсэн үнээр эргэн төлөгдөх үнэт цаасыг ойлгоно/	60%
3.6.5. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасныг ойлгоно/	60%
3.6.6. Аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл	60%
3.6.7. Компанийн өрийн хэрэгсэл /Үнэт цаасны зах зээлд арилжаалагддаг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-т заасан/	30%
3.6.8. Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн 1-р ангиллын хувьцаа	20%
3.6.9. Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн 2-р ангиллын хувьцаа	5%
3.6.10. Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө /Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийг хангасан банк бус санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгө/	20%

3.7. Давхар даатгагчийн сангийн нийт дүнгээс хөрөнгө оруулалт хийсэн дүнг хассан үлдэгдэл нь мөнгөн хөрөнгөөр байршина.

3.8. Энэ журмын 3.6, 3.7-д зааснаас бусад ангиллаар давхар даатгагчийн санг байршуулах, хөрөнгө оруулалт хийхгүй.

3.9. Давхар даатгагчийн сангаас хөрөнгө оруулах дүнг тооцохдоо давхар даатгагчийн сангийн дүнг харгалзах хөрөнгө оруулах хувиар үржүүлж тооцно.

### **Дөрөв. Давхар даатгагчийн санг зарцуулах**

4.1. Энэ журмын 2.1, 2.2-т заасан сангуудыг зөвхөн малын индексжүүлсэн даатгалын нөхөн төлбөрт зарцуулна.

4.2. Дунд түвшний эрсдэлээс хамгаалах санг эрсдэлийн дунд түвшинд нэхэмжилсэн хохирлын тус санд ногдох дүнгээр зарцуулна.

4.3. Дээд түвшний эрсдэлээс хамгаалах санг эрсдэлийн дээд түвшинд нэхэмжилсэн хохирлын тус санд ногдох дүнгээр зарцуулна.

4.4. Давхар даатгагчийн алдагдлаас хамгаалах санг зарцуулахдаа Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 болон энэ журмын 2.3-т тус тус заасныг үндэслэнэ.

4.5. Энэ журмын 2.1, 2.2-т заасан сангуудын тухайн тайлант хугацааны эцсийн үлдэгдэл нь дараагийн тайлант хугацааны эхний үлдэгдэл болно.

### **Тав. Давхар даатгагчийн санд тавих хяналт**

5.1. Давхар даатгагч татан буугдсан, дампуурсан тохиолдолд малын индексжүүлсэн даатгалын бүх нөхөн төлбөрийг олгож, хураамжийн буцаалт хийгдсэний дараах сангийн үлдэгдлийг Компанийн тухай хуульд заасны дагуу хуваарилна.

5.2. Давхар даатгагчийн сангийн хөрөнгө оруулалтын тайланг энэ журмын 1 дүгээр хавсралт **СЗХ04155** маягтын дагуу улирал бүр гаргаж, эхний хагас жилийн болон жилийн санхүүгийн тайлангийн хамт Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан хугацаанд цаасаар болон Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ны цахим бүртгэл (FINA программ)-д илгээх, 1 болон 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн хамт дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор цаасаар болон Хорооны цахим бүртгэлд илгээнэ.

5.3. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---ooOoo---

“Малын индексжүүлсэн даатгалын давхар даатгалын компанийн санг бүрдүүлэх, байршуулах, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 1 дүгээр хавсралт

**МАЯГТ СЗХ04155. ДАВХАР ДААТГАГЧИЙН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЙЛАН**

Давхар даатгагчийн нэр .....

20...оны... сарын ...-ны өдөр

(төгрөгөөр)

	Үзүүлэлт	Мөр/ дугаар	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эзлэх хувь
А	Б	В	1	2	3
<b>1</b>	<b>Бэлэн мөнгө</b>	1			
<b>2</b>	<b>Банкны харилцах (=мөр 3)</b>	2			
2.1	...банк (дансны дугаар, валют)	3			
<b>3</b>	<b>Банкны хугацаагүй хадгаламж (=мөр 5)</b>	4			
3.1	...банк (дансны дугаар, валют)	5			
<b>4</b>	<b>Банкны хугацаатай хадгаламж (=мөр 7)</b>	6			
4.1	...банк (дансны дугаар, валют)	7			
<b>5</b>	<b>Банкны хадгаламжийн сертификат (=мөр 9)</b>	8			
5.1	...банк (дансны дугаар, валют)	9			
<b>6</b>	<b>Үнэт цаас (=мөр (11+12+13+14+15+16+17))</b>	10			
6.1	Засгийн газрын өрийн хэрэгсэл	11			
6.2	Төв банкны үнэт цаас	12			
6.3	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	13			
6.4	Аймаг, нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл	14			
6.5	Компанийн өрийн хэрэгсэл	15			
6.6	Монголын хөрөнгийн биржийн 1 ангиллын хувьцаа	16			
6.7	Монголын хөрөнгийн биржийн 2 ангиллын хувьцаа	17			
<b>7</b>	<b>Тухайн давхар даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө (=мөр 19)</b>	18			
7.1	...ББСБ	19			
<b>8</b>	<b>НИЙТ ДҮН (=мөр (1+2+4+6+8+10+18))</b>	20			

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

.....  
(албан тушаал)

.....  
(гарын үсэг)

.....  
(овог нэр)

Тамга тэмдэг

Тайлан гаргасан хугацаа:

20... оны ... сарын ... өдөр